



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Рашаант сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2024/07/НА-СА-ТТЗ

|                                                                                            |                                                         |                                                                                    |
|--------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Булган аймаг<br>2023 он | Дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас: 70342580 | Цахим хаяг: <a href="mailto:erdeneb@audit.gov.mn">erdeneb@audit.gov.mn</a>         |
|                                                                                            | Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716          | Цахим хаяг: <a href="mailto:enhtsoodolj@audit.gov.mn">enhtsoodolj@audit.gov.mn</a> |
|                                                                                            | Аудитор: А.Сувдаа<br>Утас: 70342495                     | Цахим хаяг: <a href="mailto:suvdaaa@audit.gov.mn">suvdaaa@audit.gov.mn</a>         |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.03.25 № 332  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

РАШААНТ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Рашаант сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Рашаант сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах үндэслэлээр хязгаарлалттай дүгнэлт өгч байна. Үүнд:

- ОНХС-аас санхүүжсэн хөрөнгийг бүртгэл тайланд дутуу тусгасан,
- ЖДҮДС-аас олгосон зээлийн эргэн төлөх хугацаа хэтэрсэн ч дараагийн шатны арга хэмжээ авч ажиллаагүй,
- Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрдэл дутуу,
- Дотоод хяналт хангалтгүйгээс харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил зэрэг нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 14 дүгээр зүйлийн 14.4.5, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 54 дүгээр зүйлийн 54.4.5, УСНББОУС 1, 17-той нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг

006020772

шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолын нэмэлт өөрчлөлтийн дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны XII/01 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын XII/01 дүгээр тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 43.7 хувиар өссөн байна.

### **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

### **Бусад хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Рашаант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 7 хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 2,392.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 2,205.2 сая төгрөгийг зарцуулж 187.7 сая төгрөгийг дутуу зарцуулжээ.

Сумын ИТХ-ын XIII/05 дугаар тогтоолоор сумын Засаг даргын үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам-Рашаант" хөтөлбөрийн хэрэгжилтийг 91.5 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Сая.төгрөгөөр

| Үзүүлэлт                                                 | 2022.12.31     | 2023.12.31     |
|----------------------------------------------------------|----------------|----------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>                         |                |                |
| Эргэлтийн хөрөнгийн дүн                                  | 613.6          | 595.8          |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн                              | 1,791.4        | 2,216.1        |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                | <b>2,405.1</b> | <b>2,811.9</b> |
| Нийт өр төлбөрийн дүн                                    | -              | -              |
| Цэвэр хөрөнгө өмчийн дүн                                 | 2,405.1        | 2,811.9        |
| <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>               | <b>2,405.1</b> | <b>2,811.9</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>                      |                |                |
| Үйл ажиллагааны орлогын дүн                              | 3,189.9        | 2,576.6        |
| Үйл ажиллагааны зардлын дүн                              | 3,091.1        | 2,172.5        |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>                            | <b>98.7</b>    | <b>404.1</b>   |
| Үйл ажиллагааны бус үр дүн                               | 6,330.6        | 2.2            |
| Үйл ажиллагааны нийт үр дүн                              | (6,231.8)      | 401.9          |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/</b>          |                |                |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл                               | 8,636.9        | 2,405.1        |
| Тайлант оны үр дүн                                       | -              | -              |
| <b>ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>                                   | <b>8,636.9</b> | <b>401.9</b>   |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                          |                |                |
| Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                       | 2,942.4        | 2,275.8        |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн                      | 2,573.5        | 1,545.3        |
| Үйл ажиллагааны мөнгөн ЦМГ                               | 368.9          | 730.5          |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн                    | -              | -              |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн                   | 452.1          | 715.8          |
| Хөрөнгө оруулалтын ЦМГ                                   | (452.1)        | (715.8)        |
| Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ                           | (5.7)          | (173.9)        |
| Нийт ЦМГ                                                 | (88.9)         | (159.3)        |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 533.8          | 444.9          |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> | <b>444.9</b>   | <b>285.6</b>   |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>                       |                |                |
| <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 |                | <b>2,205.9</b> |
| Урсгал зардал                                            |                | 1,556.7        |
| Хөрөнгийн зардал                                         |                | 472.8          |
| <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>                    |                | <b>2,220.0</b> |
| Улсын төсвөөс санхүүжих                                  |                | -              |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих                           |                | 2,037.5        |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         |                | 182.5          |

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 7.8 сая төгрөгийн алдаа илэрснийг залруулж, 70.8 сая төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 49.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 409.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 156.0 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 1.2 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 7.5 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 244.7 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна.

### 3.2 Албан шаардлага

1. ОНХС-гаас санхүүжсэн 49.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага өгөх

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЖДҮДС-аас олгосон 21.0 сая төгрөгийн зээлийн эргэн төлөх хугацаа хэтэрсэн ч дараагийн шатны арга хэмжээ авч ажиллаагүй нь зээлийн гэрээний 4.3, Төсвийн тухай хуулийн 16.5.4, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангаас олгосон зээлийг эргэн төлүүлэх, барагдуулах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх ажлын зохион байгуулах

2. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн иж бүрдлийг ханган ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.5, иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн иж бүрдлийг ханган Төрийн аудитын газарт ирүүлж хэвших

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод хяналтын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт тайлан байхгүй нь ЗГ-ын 2011 оны 311 тогтоолын 1.5-д, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Журмын дагуу байгууллагын үйл ажиллагаа, чанар хүртээмж, өмч хөрөнгөтэй холбоотой дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа |       | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |      | Буруу тусган илэрхийлсэн |       | Үүнээс     |       |              |     | Зөвлөмж |     |
|------------------|------------|-------|-----------------------------------|------|--------------------------|-------|------------|-------|--------------|-----|---------|-----|
|                  |            |       |                                   |      |                          |       | Залруулсан |       | Залруулаагүй |     |         |     |
|                  | Тоо        | Дүн   | Тоо                               | Дүн  | Тоо                      | Дүн   | Тоо        | Дүн   | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| ЗДТГ             | 2          | 162.6 | 1                                 | 29.3 | 1                        | 133.4 | 2          | 162.6 | 0            | -   | 0       | -   |
| ТТЗ              | 2          | 7.8   |                                   |      | 2                        | 7.8   | 2          | 7.8   |              |     |         |     |
| Дүн              | 4          | 170.4 | 1                                 | 29.3 | 3                        | 141.2 | 4          | 170.4 | 0            | 0   | 0       | 0   |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил |              | Үүнээс        |            |                 |             |          |              |                                      |                     |                                                 |          |
|------------------|-------------|--------------|---------------|------------|-----------------|-------------|----------|--------------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|----------|
|                  |             |              | Төлбөрийн акт |            | Албан шаардлага |             | Зөвлөмж  |              | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|                  | Тоо         | Дүн          | Тоо           | Дүн        | Тоо             | Дүн         | Тоо      | Дүн          | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн      |
| ЗДТГ             | 4           | 2.2          | 2             | 1.2        | 1               | 1.1         | 1        | -            |                                      |                     |                                                 |          |
| ИТХ              | 1           | 5.7          |               |            | 1               | 5.7         |          |              |                                      |                     |                                                 |          |
| ХХС              | 2           | 0.7          |               |            | 1               | 0.7         | 1        | 0            |                                      |                     |                                                 |          |
| ОНХС             | 1           | 244.7        |               |            |                 |             | 1        | 244.7        |                                      |                     |                                                 |          |
| ТТЗ              | 4           | 70.8         | 0             | 0          | 1               | 49.9        | 3        | 20.9         |                                      |                     |                                                 |          |
| <b>Дүн</b>       | <b>12</b>   | <b>324.1</b> | <b>2</b>      | <b>1.2</b> | <b>4</b>        | <b>57.4</b> | <b>6</b> | <b>265.6</b> | <b>0</b>                             | <b>0</b>            | <b>0</b>                                        | <b>0</b> |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

| Байгууллагын нэр                                         | Нийт зөрчил |                | Үүнээс        |          |                 |                |          |             |
|----------------------------------------------------------|-------------|----------------|---------------|----------|-----------------|----------------|----------|-------------|
|                                                          |             |                | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |                | Зөвлөмж  |             |
|                                                          | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн            | Тоо      | Дүн         |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |                |               |          |                 |                |          |             |
| ЗДТГ                                                     | 1           | 264.5          | 0             | -        | 1               | 264.5          | 0        | -           |
| ИТХ                                                      | 1           | 22.0           |               |          |                 |                | 1        | 22.0        |
| ОНХС                                                     | 1           | 947.2          |               |          | 1               | 947.2          |          |             |
| ХХС                                                      | 1           | 346.0          |               |          | 1               | 346.0          |          |             |
| ТТЗ                                                      | 1           | 0              |               |          |                 |                | 1        | 0           |
| <b>Дүн</b>                                               | <b>5</b>    | <b>1,579.7</b> | <b>0</b>      | <b>0</b> | <b>3</b>        | <b>1,557.7</b> | <b>2</b> | <b>22.0</b> |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |                |               |          |                 |                |          |             |
| ЗДТГ                                                     | 1           | 17.4           | 0             | -        | 1               | 17.4           | 0        | -           |
| <b>Дүн</b>                                               | <b>1</b>    | <b>17.4</b>    | <b>0</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>17.4</b>    | <b>0</b> | <b>-</b>    |
| <b>Нийт дүн</b>                                          | <b>6</b>    | <b>1,597.1</b> | <b>0</b>      | <b>0</b> | <b>4</b>        | <b>1,575.1</b> | <b>2</b> | <b>22.0</b> |

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 |                         |                |       |                            |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 4                        | 1                           | 3                  |                 | 1                       |                |       |                            |
| 2 | Төсөл, хөтөлбөр             | 0                        |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 3 | ЗГТС                        | 0                        |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 4 | ТТЗ                         | 1                        | 1                           |                    |                 |                         | 1              |       |                            |
|   | НИЙТ                        | 5                        | 2                           | 3                  | 0               | 1                       | 1              | 0     | 0                          |